ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2025/18/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**0**

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....2**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....4**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/....4**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ ....5**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/....6**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ ....8**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....10**

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ....** Error! Bookmark not defined.

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .... **Error! Bookmark not defined.**

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.... **Error! Bookmark not defined.**

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .... **Error! Bookmark not defined.**

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд **Error! Bookmark not defined.**

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... **Error! Bookmark not defined.**

**4. АУДИТЫН ТАЙЛАН ....** Error! Bookmark not defined.

**4.1 Ерөнхий зүйл ....Error! Bookmark not defined.**

**4.2 Материаллаг байдал ....Error! Bookmark not defined.**

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....**Error! Bookmark not defined.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....**Error! Bookmark not defined.**

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .... Error! Bookmark not defined.**

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.... Error! Bookmark not defined.**

**4.5.1 Завсрын аудитын талаар.... Error! Bookmark not defined.**

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .... Error! Bookmark not defined.**

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....10**

**5.1 Төлбөрийн акт** .... 11

**5.2 Зөвлөмж**.... 11

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....16**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг; dundgovi@audit.gov.mn

2025.01.28 № 02

танай ______ -ны № ______ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.УРАНЦЭЦЭГ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 164.6 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Харин тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, орлого авсан байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд дээрх зөрчил арилсан тул дүгнэлтэд нөлөөлөөгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт, 67 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 205,075,365.87 | 219,012,355.39 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4,300,011.00 | 3,170,762.52 |
| 311 | Кассад байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 4,300,011.00 | 3,170,762.52 |
| 3121 | Төгрөг | 4,300,011.00 | 3,170,762.52 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | 40,751.52 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 4,300,011.00 | 3,130,011.00 |
| 314 | Замд яваа мөнгөн хөрөнгө | | |
| 33 | АВЛАГА | 17,405,910.00 | 26,570,233.00 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 7,082,899.00 | 6,837,148.00 |
| 335 | Бусад авлага | 10,323,011.00 | 19,733,085.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 9,410,074.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 10,323,011.00 | 10,323,011.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 183,369,444.87 | 189,271,359.87 |
| 351 | Түүхий эд материал | 44,102,500.00 | 15,835,785.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 44,102,500.00 | 15,835,785.00 |
| 354 | Хангамжийн материал | 139,266,944.87 | 173,435,574.87 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 3,853,296.00 | 3,098,296.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 126,774,048.87 | 166,481,198.87 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | | 3,661,080.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 8,639,600.00 | 195,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,608,908,107.18 | 1,878,695,416.36 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,608,908,107.18 | 1,878,695,416.36 |
| 392 | Биет хөрөнгө | 1,589,412,367.63 | 1,860,157,001.77 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,564,105,968.93 | 1,958,304,900.93 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -446,968,250.80 | -540,780,840.51 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 380,795,705.00 | 370,165,705.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -181,529,316.17 | -218,678,316.34 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 199,288,501.00 | 196,654,462.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -86,352,339.41 | -80,653,203.99 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 71,645,600.00 | 77,828,821.68 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -41,305,311.96 | -28,003,540.05 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 144,876,038.20 | 144,876,038.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -15,144,227.16 | -19,557,026.08 |
| 393 | Биет бус хөрөнгө | 19,495,739.55 | 18,538,414.59 |
| 39301 | Програм хангамж | 5,536,625.00 | 5,536,625.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,148,885.45 | -2,106,210.41 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 15,108,000.00 | 15,108,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,813,983,473.05 | 2,097,707,771.75 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 8,728,358.97 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 8,728,358.97 |
| 413 | Өглөг | | 8,728,358.97 |
| 4136 | Бусад өглөг | | 8,728,358.97 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 8,728,358.97 |
| 414 | Урьдчилж орсон орлого | | |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | |
| 422 | Урт хугацаат зээл | | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,813,983,473.05 | 2,088,979,412.78 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,813,983,473.05 | 2,088,979,412.78 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 606,602,224.60 | 606,602,224.60 |
| 5E+05 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 5E+05 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 788,517,258.18 | 1,063,513,197.91 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 788,517,258.18 | 788,517,258.18 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 274,995,939.73 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 418,863,990.27 | 418,863,990.27 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,813,983,473.05 | 2,097,707,771.75 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,005,123,147.00 | 1,527,875,695.15 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 337,061,356.00 | 573,006,876.15 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 337,061,356.00 | 573,006,876.15 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,923,211.00 | 14,475,825.52 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,323,200.00 | 5,025,000.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 9,410,074.00 |
| 1E+06 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 4,600,011.00 | 40,751.52 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 268,786,145.00 | 461,759,715.63 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 59,352,000.00 | 96,771,335.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 668,061,791.00 | 954,868,819.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 82,992,891.00 | 96,176,719.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 15,000,000.00 | 51,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,831,198.00 | 34,492,536.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,161,693.00 | 10,084,183.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 585,068,900.00 | 858,692,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 585,068,900.00 | 858,692,100.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 823,999,230.46 | 1,243,136,396.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 823,999,230.46 | 1,243,136,396.60 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 768,881,989.95 | 1,108,204,384.44 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 325,483,787.00 | 491,454,671.00 |
| 210101 | Үндсэн цалин | 244,085,254.00 | 293,069,515.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,096,405.00 | 172,570,951.00 |
| 210104 | Урамшуулал | 20,302,128.00 | 25,814,205.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,900,459.00 | 60,628,482.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,512,364.00 | 41,658,828.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,254,372.00 | 4,639,303.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,545,365.00 | 2,581,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 566,486.00 | 2,291,521.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,021,872.00 | 9,457,230.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,261,254.24 | 23,565,011.84 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,364,352.48 | 6,082,529.12 |
| 210302 | Түлш, халаалт | 15,896,901.76 | 17,482,482.72 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 64,980,153.25 | 58,089,670.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,677,944.00 | 5,980,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,067,797.80 | 34,067,120.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,519,961.45 | 1,287,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,502,000.00 | 9,672,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,787,500.00 | 7,082,750.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,424,950.00 | |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 32,550,550.00 | 38,395,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 32,550,550.00 | 38,395,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,691,000.00 | 15,972,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,691,000.00 | 15,972,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,211,121.00 | 30,165,525.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,748,298.00 | 28,833,256.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 684,000.00 | 509,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 146,020.00 | 347,864.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 112,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 180,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 217,803.00 | 183,305.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 247,803,665.46 | 389,933,924.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,557,038.00 | 198,452,518.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,240,000.00 | 524,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 178,006,627.46 | 190,957,406.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,117,240.51 | 134,932,012.16 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,690,400.00 | 55,303,900.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,090,400.00 | 7,182,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 9,473,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 25,526,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 10,122,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 42,426,840.51 | 79,628,112.16 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,426,840.51 | 79,628,112.16 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 181,123,916.54 | 284,739,298.55 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 2,781,616.52 | 9,743,358.82 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 471,666.52 | 1,014,999.85 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 8,728,358.97 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 2,309,950.00 | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -2,781,616.52 | -9,743,358.82 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 178,342,300.02 | 274,995,939.73 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 676,985,002.00 | 959,934,570.52 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,923,211.00 | 5,065,751.52 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,923,211.00 | 5,065,751.52 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,923,211.00 | 5,065,751.52 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,323,200.00 | 5,025,000.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 4,600,011.00 | 40,751.52 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 668,061,791.00 | 954,868,819.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 82,992,891.00 | 96,176,719.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 15,000,000.00 | 51,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,831,198.00 | 34,492,536.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,161,693.00 | 10,084,183.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 585,068,900.00 | 858,692,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 585,068,900.00 | 858,692,100.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 625,670,636.00 | 961,063,819.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 625,670,636.00 | 961,063,819.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 570,553,395.49 | 826,131,806.84 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 326,568,904.00 | 491,248,680.00 |
| 210101 | Үндсэн цалин | 245,170,371.00 | 292,863,524.00 |
| 210102 | Нэмэгдэл | 61,096,405.00 | 172,570,951.00 |
| 210104 | Урамшуулал | 20,302,128.00 | 25,814,205.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,940,219.00 | 60,588,722.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,552,124.00 | 41,619,068.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,254,372.00 | 4,639,303.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,545,365.00 | 2,581,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 566,486.00 | 2,291,521.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,021,872.00 | 9,457,230.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,261,254.24 | 23,565,011.84 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,364,352.48 | 6,082,529.12 |
| 210302 | Түлш, халаалт | 15,896,901.76 | 17,482,482.72 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 43,940,559.25 | 57,964,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,687,800.00 | 5,225,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,067,797.80 | 37,728,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,519,961.45 | 1,287,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,502,000.00 | 9,672,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,163,000.00 | 4,051,000.00 |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 37,835,550.00 | 29,950,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 37,835,550.00 | 29,950,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,691,000.00 | 15,972,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,691,000.00 | 15,972,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,211,121.00 | 30,165,525.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,748,298.00 | 28,833,256.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 684,000.00 | 509,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 146,020.00 | 347,864.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 112,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 180,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 217,803.00 | 183,305.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,104,788.00 | 116,677,368.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,864,788.00 | 116,153,368.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,240,000.00 | 524,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,117,240.51 | 134,932,012.16 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,690,400.00 | 55,303,900.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,090,400.00 | 7,182,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 9,473,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 25,526,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 10,122,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 42,426,840.51 | 79,628,112.16 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,426,840.51 | 79,628,112.16 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 51,314,366.00 | -1,129,248.48 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 47,014,355.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 47,014,355.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 47,014,355.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -47,014,355.00 | |
| 145 | Бусад эх үүсвэр | | |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |

| | | | |
|---|---|---|---|
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 4,300,011.00 | -1,129,248.48 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 4,300,011.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 3,170,762.52 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 178,342,300.02 | 178,342,300.02 |
| 8 | ................ | | | | |
| 9 | ................ | | | | |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 606,602,224.60 | 418,863,990.27 | 788,517,258.18 | 1,813,983,473.05 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 274,995,939.73 | 274,995,939.73 |
| 18 | ................ | | | | |
| 19 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 606,602,224.60 | 418,863,990.27 | 1,063,513,197.91 | 2,088,979,412.78 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 860,692,100.00 | 820,921,910.84 | 39,770,189.16 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 860,692,100.00 | 820,921,910.84 | 39,770,189.16 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 804,642,200.00 | 765,618,010.84 | 39,024,189.16 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 519,687,500.00 | 491,248,680.00 | 28,438,820.00 |
| 210101 | Үндсэн цалин | 291,037,100.00 | 292,863,524.00 | -1,826,424.00 |
| 210102 | Нэмэгдэл | 192,538,200.00 | 172,570,951.00 | 19,967,249.00 |
| 210104 | Урамшуулал | 36,112,200.00 | 25,814,205.00 | 10,297,995.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 65,828,500.00 | 60,588,722.00 | 5,239,778.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,763,300.00 | 41,619,068.00 | 3,144,232.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,266,300.00 | 4,639,303.00 | 626,997.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,633,200.00 | 2,581,600.00 | 51,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,633,200.00 | 2,291,521.00 | 341,679.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,532,500.00 | 9,457,230.00 | 1,075,270.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,725,200.00 | 23,565,011.84 | 160,188.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,242,600.00 | 6,082,529.12 | 160,070.88 |
| 210302 | Түлш, халаалт | 17,482,600.00 | 17,482,482.72 | 117.28 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 47,165,800.00 | 46,400,560.00 | 765,240.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,225,800.00 | 5,225,800.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,196,000.00 | 26,164,760.00 | 31,240.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,439,000.00 | 1,287,000.00 | 152,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,254,000.00 | 9,672,000.00 | 582,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,051,000.00 | 4,051,000.00 | |
| 2105 | Нормативт зардал | | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 30,025,500.00 | 29,950,500.00 | 75,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,025,500.00 | 29,950,500.00 | 75,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,266,000.00 | 15,972,000.00 | 294,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,266,000.00 | 15,972,000.00 | 294,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,609,700.00 | 4,089,169.00 | 1,520,531.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,761,700.00 | 2,756,900.00 | 4,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 916,000.00 | 509,100.00 | 406,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 528,000.00 | 347,864.00 | 180,136.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 210,000.00 | 112,000.00 | 98,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 684,000.00 | 180,000.00 | 504,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 510,000.00 | 183,305.00 | 326,695.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,334,000.00 | 93,803,368.00 | 2,530,632.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 93,584,000.00 | 93,279,368.00 | 304,632.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,750,000.00 | 524,000.00 | 2,226,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 56,049,900.00 | 55,303,900.00 | 746,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 56,049,900.00 | 55,303,900.00 | 746,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 3,000,000.00 | 3,000,000.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,400,000.00 | 7,182,000.00 | 218,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 9,473,900.00 | 9,473,900.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 25,526,000.00 | 25,526,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,650,000.00 | 10,122,000.00 | 528,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | | | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 860,692,100.00 | 816,662,651.36 | 44,029,448.64 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 860,692,100.00 | 818,896,910.84 | 44,029,448.64 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 860,692,100.00 | 818,896,910.84 | 44,029,448.64 |
| 133 | ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС | | | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,000,000.00 | -2,234,259.48 | -234,259.48 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 2,025,000.00 | -25,000.00 |
| 1E+06 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | | -4,259,259.48 | 4,259,259.48 |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,300,011.00 | 4,300,011.00 | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 3,170,762.52 | -3,170,762.52 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 96,176,719.00 | -96,176,719.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 96,176,719.00 | -96,176,719.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 56,343,796.00 | -56,343,796.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 11,563,440.00 | -11,563,440.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 11,563,440.00 | -11,563,440.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 26,076,356.00 | -26,076,356.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 26,076,356.00 | -26,076,356.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 18,704,000.00 | -18,704,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 18,704,000.00 | -18,704,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 39,832,923.00 | -39,832,923.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | | |
| | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 39,832,923.00 | -39,832,923.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 96,176,719.00 | -96,176,719.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 96,176,719.00 | -96,176,719.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 51,600,000.00 | -51,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 34,492,536.00 | -34,492,536.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 10,084,183.00 | -10,084,183.00 |
| | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 181,232.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 206.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,911.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой 179,115.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж тус тус хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт 206.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын авлагыг санхүүгийн тайланд 206.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 181,026.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч, нөхөн төлүүлэх төлбөрийн акт, зөрчил арилгах зөвлөмж хүргүүллээ.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэлээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Төлбөрийн акт

- Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчид 749.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т /*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*/, Хөдөлмөрийн тухай хуулийн 57.3.3-т /*Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина*/, 84.4-т /*Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна*/ заасныг;
- Албан хаагчид анхан шатны хүчин төгөлдөр баримт /аймгийн Засаг даргын захирамж/-ыг үндэслээгүй, ажиллаагүй хоногт 811.7 мянган төгрөгийн илүү цалин олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/ заасныг;
- Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлсний орлогоос орон нутгийн орлогод төвлөрүүлэх 30 хувь буюу 349.5 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т /*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 2.5-д /*Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 70 хувийг Байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлж, барилга байгууламжийн засвар, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд зарцуулж болно. Тус орлогын 30 хувийг Төрийн сангийн Хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ. Орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг улирал болгоны сүүлийн сарын 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт гаргаж өгнө*/ заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Хэтрүүлэн олгосон 1,561.5 мянган төгрөгийн цалинг орон нутгийн орлогын 100080000955 тоот дансанд, дутуу төвлөрүүлсэн 349.5 мянган төгрөгийн орлогыг 100080000953 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.*

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой

*Илрүүлэлт:*

Элэгдлээ бүрэн нөхсөн 179,115.8 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, үнэлэх арга хэмжээ аваагүй.

Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-т /*Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, үнэлэх арга хэмжээ авч, жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж ирүүлэх.

*Зөвлөмжийн хэрэгжилт*:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар давтан шалгахад элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хувь хүний орлогын албан татварын авлагыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан. | 1 | 206.0 | | | 1 | 206.0 | 1 | 206.0 | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **206.0** | **0** | **0** | **1** | **206.0** | **1** | **206.0** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Түрээсийн орлогоос орон нутгийн орлогод төвлөрүүлэх 30 хувийг төвлөрүүлээгүй. | 1 | 349.5 | 1 | 349.5 | | | | | | |
| Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй. | 1 | 179,115.8 | | | | | 1 | 179,115.8 | | |
| Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон. | 1 | 749.9 | 1 | 749.9 | | | | | | |
| Албан хаагчид анхан шатны хүчин төгөлдөр баримт /аймгийн Засаг даргын захирамж/-ыг үндэслээгүй, ажиллаагүй хоногт илүү цалин бодож олгосон. | 1 | 811.7 | 1 | 811.7 | | | | | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **181,026.9** | **3** | **1,911.0** | **-** | **-** | **1** | **179,115.8** | **-** | **-** |